



**МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,  
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn  
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

2018.06.25 № 1/1982  
танай 2018.05.21 -ны № 24 -т

Г Асуулгын хариу хүргүүлэх тухай

Тус яаманд хандаж Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нараас Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурч байгаа эсэх, цаашид авах арга хэмжээний талаар асуулга тавьсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтад "Асуулга тавьсан гишүүн өөрөө хүсвэл түүний хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно." гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нар асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулахыг хүссэн байна.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулахаар асуулгын хариуг боловсруулан, яамдаас ирүүлсэн албан бичгийн хуулбарын хамт хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 13. хуудас

Хувийг: ЗГХЭГ, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нарт

Хүндэтгэсэн,



С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2018 оны 06 дугаар сарын 25 өдрийн //98 тоот  
албан бичгийн хавсралт

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ, Ж.ЭНХБАЯР НАРААС ИРҮҮЛСЭН АСУУЛГЫН ХАРИУ

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нараас ирүүлсэн асуулгын хариуг зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний асуудал эрхэлсэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Батлан хамгаалахын яамнаас ирүүлсэн санал, тоо мэдээлэлд үндэслэн боловсруулав.

### Асуулт 1:

"УИХ-аас 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 2-т цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т, 7 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хувааж тодорхойлно, "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль-ийн 1 дүгээр зүйлд "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын цалин хөлсний дараалсан жил нь 2019 онд 6 жил, 2020 онд 7 жил, цалин хөлсний нийлбэрийн хуваагдах сарын тоо 2019 онд 72 сар, 2020 онд 84 сар байна" гэж тус тус заасан нь зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах нөхцөл байдал бүрдүүлсэн эсэх"

### Хариулт 1:

Монгол Улсын тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банк, Олон Улсын хөдөлмөрийн байгууллага, бусад олон улсын байгууллагаас үнэлгээ хийсэн бөгөөд уг үнэлгээгээр Монгол улсад 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсч, 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2017 оны хувьд 4, 2030 он гэхэд 7, цаашид 9 тэтгэвэр авагч болохоор байна.

Ирээдүйд бий болох хүн ам зүйн ачааллын өсөлт, насжилтыг утгаж тэтгэврийн сангийн алдагдлыг бууруулах, даатгалын тогтолцоог шинэчлэх,

ахмад настны хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд тэтгэврийн насыг иргэнд хүндрэл багатайгаар үе шаттай, урт хугацаанд нэмэгдүүлэх, даатгуулагчийн шимтгэл төлсөн бүх жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож тэтгэврийг бодитой, шударга тогтоох асуудлыг Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-д тусгасан билээ.

Түүнчлэн даатгуулагчийн шимтгэл төлсөн сүүлийн 5 жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож, тогтоож байгаа нь сайн дурын даатгуулагч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаад тэтгэвэр тогтоолгохоос 5 жилийн өмнө өндөр шимтгэл төлж, өндөр тэтгэвэр тогтоолгох шударга бус хандлага үүсээд байгаа юм.

Харин олон жил тогтвортой шимтгэл төлж, ажилласан даатгуулагч сайн дурын даатгалд даатгуулсан даатгуулагчдаас бага тэтгэвэр тогтоолгож байна.

Иймд даатгуулагчийн тэтгэврийг ажилласан жил, төлсөн шимтгэлтэй нь уялдуулан бодитой, шударга тогтоох зорилгоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдөр даатгуулагчийн шимтгэл төлсөн долоон жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож тогтоохоор нэмэлт, өөрчлөлт оруулан Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар баталсан.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх зорилгоор 2019 онд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг 2019 оны төсөвт тусгуулахаар төсвийн хүрээний мэдэгдэлд санал хүргүүлэн, тусгуулсан болно.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор баталсан тэтгэвэр бodoх цалингийн итгэлцүүрийг инфляцийн түвшин, улсын дундаж цалин, хөдөлмерийн хөлсний доод хэмжээ, амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан тооцвол 2019 онд тэтгэвэр бodoх цалингийн итгэлцүүрийг 6-15 хувиар нэмэгдэх шаардлагатай байна.

Цэргийн алба хаагчдын 5-7 жилийн хөдөлмөрийн хөлсний дундаж<sup>1</sup>, /хошууч цолтой, ТТ-10-5-ТТ-12-5 цалингийн шатлал бүхий цэргийн алба хаагчийн дундаж цалинд үндэслэв/ 2019 оноос шинэчлэх цалингийн итгэлцүүрийг тус тус үндэслэн цэргийн алба хаагчийн 2019-2020 оны тэтгэврийн хэмжээг тооцоход тэтгэврийн хэмжээ өнөөдрийн түвшингээс 8792-19430 төгрөгөөр нэмэгдэхээр байна. /Хүснэгт 1-ээс харах/

<sup>1</sup> Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэв.

**Хүснэгт 1. Цэргийн алба хаагчийн тэтгэврийн тооцоо**

Тэтгэвэр бодох жил	Дундаж цалин, хөлс		Тэтгэврийн хэмжээ /төгрөг/
2019 он	5 жил	өнөөдрийн түвшинд	1,139,646
		итгэлцүүр нэмэгдүүлэхэд	1,151,304
		<b>Зөрүү</b>	<b>11,658</b>
2019 он	6 жил	өнөөдрийн түвшинд	1,111,623
		итгэлцүүр нэмэгдүүлэхэд	1,135,910
		<b>Зөрүү</b>	<b>24,288</b>
2020 он	7 жил	өнөөдрийн түвшинд	1,124,920
		итгэлцүүр нэмэгдүүлэхэд	1,145,738
		<b>Зөрүү</b>	<b>20,818</b>

Иймд дээрх тооцооноос харахад 2019 онд тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг нэмэгдүүлснээр 2019 онд 6 жилийн, 2020 онд 7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр бодож тогтоолгох нь тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэхгүй юм.

**Асуулт 2:**

"2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх "Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2017 оны 75 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5-д "Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэн батлах, хүчингүй болгох"-ыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Дээрх хуулийн өөрчлөлтүүдтэй холбоотойгоор Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дахин өөрчлөлт орох эсэх, хэрэв өөрчлөлт орвол дээр дурдсан алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмж зөвхөн үндсэн цалингаас бодогдож, үүнээс үүдэн тэтгэвэр тэтгэмж буурах эсэх талаар"

## **Хариулт 2:**

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх Төрийн албаны тухай хуулийн 60.1 дэх хэсэгт “Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насын тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусlamжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусlamжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна...” гэжээ.

“Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д “Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг энэ хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулна.” гэж заасан.

2018 оны байдлаар зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчдын тэтгэмжийг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд **36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.**” гэж заасны дагуу сарын нийт цалин хөлснөөс тооцон олгож байна.

Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчийн сүүлийн 5 жилийн нийт цалин хөлсний дунджаас 36 сарын тэтгэмж тооцоход 2018 онд дунджаар 41.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж авч байна. Харин үндсэн цалингаас тэтгэмжийг тооцно гэж үзвэл 24.6 сая төгрөг болох буюу нийт цалингаас тооцсон тэтгэмжээс 16.4 сая төгрөгөөр буурч, эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, ард иргэдийн аюулгүй байдлыг хангахаар өдөр, шөнөгүй үүрэг авч ажилладаг дээрх алба хаагчийн нийгмийн баталгаа алдагдахаар байна.

Иймд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж” гэж өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд цэргийн алба хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийг нийт цалин хөлснөөс бодож тогтоодог одоогийн зарчмыг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзэж байна.

## **Асуулт 3:**

“Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас энэ онд хэчнээн алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэр

*"тогтоолгох хүсэлтээ гаргав, үүнд хэдий хэмжээний санхүүжилт шаардлагатай байгаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар"*

### **Хариулт 3:**

Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудад ажиллаж буй алба хаагчдаас 2018 онд 787 алба хаагч өндөр насын тэтгэвэр тогтоолгоо, тэдний нэг удаагийн тэтгэмжид 27.2 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан.

Дээрх алба хаагчдын дунд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлснээр нэг удаагийн тэтгэмжийг үндсэн цалингаас тооцно гэсэн ташаа мэдээлэл гарснаас үүдэн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө өндөр насын тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан алба хаагчдын тоо 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1.6 дахин өсч, уг арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ батлагдсан төсвөөс 23.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх төлөвтэй байна. /Хүснэгт 3-аас харах/

**Хүснэгт 3.** Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудын нэг удаагийн буцалтгүй тусlamж, тэтгэмж авах алба хаагчдын тоо, хөрөнгийн хэмжээ

/тэрбум төгрөг/

2018 оны төлөвлөгөө		2018 оны ХБГ		Зөрүү	
Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө
787	27.2	1289	51.0	502	23.8

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр насын тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөө авч буй зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудын алба хаагчдын тухайд өндөр насын тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргах болсон гол шалтгаан нь нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ буурна гэсэн ташаа мэдээлэлтэй шууд холбоотой байна.

Энэхүү ташаа мэдээллээс болж өндөр насын тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж буй алба хаагчийн тоо нэмэгдсэнээр дараах сөрөг үр дагаварыг бий болгож байна. Үүнд:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад хүний нөөц, боловсон хүчний хомсдол үүсэх;
2. Тэтгэмж болон тэтгэвэр авагчийн тоо нэмэгдэж улмаар улсын төсөвт нэмэлт ачаалал үзүүлэх;
3. Албан хаагч ажиллах сонирхол байсан хэдий ч тэтгэмж авах зорилгоор харьцангуй эрт тэтгэвэр тогтоолгож, ажилгүй болох.

Иймд цаашид албан хаагчдыг бодит мэдээллээр хангах, ташаа мэдээллээс үүдэн өндөр насны тэтгэвэр тогтоолгооор өргөдөл гаргасан алба хаагчийн хүсэлтийг хойшлуулахаар зөвшилцөх, нэг удаагийн тэтгэмжид олгооор 2018 онд батлагдсан төсөвт багтаан байгууллагууд дотооддоо зохицуулалт хийн тэтгэмжийг олгон ажиллаж байна.

Түүнчлэн өнөөдрийн байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар даатгуулагчийн шимтгэл төлсөн долоон жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож тогтоох болсонтой холбогдуулан иргэнээс өргөдөл гарган ирүүлээгүй байна.

#### **Асуулт 4:**

*"Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх чиглэлээр цаашид Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлж байгаа талаар"*

#### **Хариулт 4:**

Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.Үүнд:

1. Эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах чиг үүргийг тасралтгүй гүйцэтгэж буй зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад өндөр насны тэтгэвэрт гаражад олгодог нэг удаагийн тэтгэмжийг түүний 5 жилийн нийт цалин хөлснөөс тооцон олгож байхаар нэг мөр шийдвэрлэх, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх,

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалт /даатгуулагчийн шимтгэл төлсөн долоон жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас тэтгэвэр бодож тогтоох/, Цэргийн алба хаасны тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэхтэй холбогдуулан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх зорилгоор тэтгэвэр бодох цалингийн

итгэлцүүрийг шинэчлэх, холбогдон гарах зардлыг 2019 оны төсөвт тусган, хэрэгжүүлэх;

3. Мөн Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно” гэсэнтэй нийцүүлэн Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын харьяа анги, байгууллагын тусгай эмнэлэг”-ийн анхан болон лавлагаа шатлалын тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа субъектийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, тусlamж үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн энгийн эмч, ажилтан нарын нийгмийн баталгаагаар хангагдах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн батлах.

#### **ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 51, Засгийн газрын VII байр,  
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 01 12,  
E-mail: info@mod.gov.mn, http://www.mod.gov.mn

дэлж 06/15 № 19/2539  
танай дэлж 06/06-ны № 11/1766-т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нараас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандан “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлт, “Төрийн албаны тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл болон шүүх шинжилгээний алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээнд өөрчлөлт орох эсэх, тэтгэвэрт гарах албан хаагчийн тоо, зардлын хэмжээ зэрэг асуулгын 3, 4 дэх хэсэгтэй холбоотой батлан хамгаалахын алба хаагчдын талаарх мэдээллийг бэлтгэн, үүгээр хүргүүлж байна. Үүнд:

1. Асуулга 3: “Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас энэ онд хичнээн алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргав, үүнд хэдий хэмжээний санхүүжилт шаардлагатай байгаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар”.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчиний Жанжин штаб, харьяа цэргийн нэгтгэл, анги, байгууллагуудын цэргийн жинхэнэ алба хаагч нараас “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, цэргийн алба хаагчдын тэтгэврийг бodoх аргачлалд орсон өөрчлөлттэй холбоотойгоор 2018 онд цэргийн тэтгэвэр тогтоолгох саналаа өгч, шаардагдах зардал нь улсын төсөвт тусгагдсан цэргийн алба хаагчдаас гадна энэ оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар 104 цэргийн алба хаагч цэргийн алба хаасны цэргийн тэтгэвэр тогтоолгох өргөдлөө нэмж өгөөд байна. Дээрх цэргийн алба хаагч нарын хуульд заасан нэг удаагийн тэтгэмжийг олгох зардлыг дундажаар тооцоход 4,1 тэрбум төгрөг нэмэгдэх хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

2. Асуулга 4: “Зэвсэгт хүчин, хил хамгаалах алба, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх чиглэлээр цаашид Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлж байгаа талаар”.

Батлан хамгаалах яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтарсан ажлын хэсэг 2016 онд “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулан 2017 оны 01 дүгээр сард Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

000011

"Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цэргийн алба хаагчийн болон тэдгээрийн гэр бүлийн нийгмийн баталгаа хангагдах дараах эрх зүйн давууд бий болсон юм. Үүнд:

- цэргийн алба хаагч нь иргэний байгууллагад ажилласан жилээ цэргийн байгууллагад ажилласнаар шилжүүлэн тооцуулж тэтгэврээ нэмэгдүүлэх;
- тэтгэвэр тогтооход ажилласан сарыг нэмэгдүүлэн тооцох;
- ажил хөдөлмөр эрхлээгүй байх үедээ хөдөлмөрийн чадвараа алдвал хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоо;
- тухайн иргэн нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоон олгох зэрэг болно.

Мөн Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичигт "Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэсэнтэй нийцүүлэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлциүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шийдвэр гарсан.

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын харьяа анги, байгууллагад анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн энгийн эмч, ажилтан нарын нийгмийн баталгаагаар хангагдах боломж бүрдэж, Эрүүл мэндийн тухай хуульд заасан "тусгай эмнэлэг"-ийн анхан болон лавлагаа шатлалын тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа субъектийн эрх зүйн байдал тодорхой болж, хөдөлмөрийн ажиллах нөхцөл хангагдаж, хуулийг зөв ~~оинтож хэрэглэх~~ эрх зүйн үндэс бүрдэх юм.

Хүндэтгэсэн,



Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж б/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2018.06.08 № 1-4/2895  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

### Хариу өгөх тухай

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Батзандан нараас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандан тавьсан асуулгын цагдаагийн байгууллагын алба хаагчдын талаар холбогдох мэдээллийг хүргүүлэв.

Сүүлийн үед цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж авахаар хүсэлтээ илэрхийлэх тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд оруулсан өөрчлөлт болон Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбоотой гэж үзэхээр байна. Тухайлбал:

1. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "тэтгэвэр тогтоолгоход баримтлах сарын дундаж цалин хөлсийг сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийг 60 сард хуваан тооцох"-оор байсныг Улсын Их Хурлаас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр өөрчилж, 2019 оноос 6 жил буюу 72, 2020 оноос 7 жил буюу 84 сарын цалин хөлсний нийлбэрийн дунджаас тооцох болсон нь тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ буурах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх Төрийн албаны тухай хуулийн 60.1 дэх хэсэгт "Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгуй тусlamжийг олгоно. Нэг удаагийн буцалтгуй тусlamжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна..." гэжээ.

Хэдийгээр энэхүү зохицуулалтад цагдаа, дотоодын цэргийн алба хаагч хамаарахгүй боловч "Төрийн албаны тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2017 оны 75 дугаар тогтоолын 1 дэх заалтын 5-д "Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд заасны дагуу 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журам, шийдвэрийг боловсруулах, өөрчлөх, шинэчлэн батлах, хүчингүй болгох"-ыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Дээрх хуулийн өөрчлөлтуүдээс шалтгаалан алба хаагчдын дунд тэтгэвэр, тэтгэмж буурах, түүнчлэн Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай холбогдуулан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн үйлчлэлээс цагдаагийн алба хаагч хасагдаж, авах тэтгэвэр, тэтгэмж үндсэн цалингаас бодогдоно гэсэн болгоомжлолтой байна.


Цагдаагийн байгууллагаас 2016 онд 257 алба хаагчид 5.9 тэрбум төгрөг, 2017 оны 231 алба хаагчид 6.9 тэрбум төгрөгийг цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон үндэслэлээр нэг удаагийн тэтгэмж болгон олгосон бөгөөд одоогоор тэтгэвэр тогтоолгосон 263 алба хаагчид олгогдвол зохих 9.7 тэрбум төгрөгийн өглөг үүсээд байгааг энэ онд төсвийн тодотгол хийсэн тохиолдолд зардлыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Мөн цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 526 алба хаагч энэ онд багтаж цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ урьдчилсан байдлаар илэрхийлсэн нь нэг удаагийн тэтгэмжид 21.3 тэрбум төгрөг, тэтгэмжийн үлдэгдэл буюу өглөг 9.7 тэрбум төгрөгтэй нийлээд нийт 31.0 тэрбум төгрөг шаардлагатай тооцоо гарсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас ойрын хугацаанд олон алба хаагчид цэргийн тэтгэвэр тогтоолгохоор албанаас чөлөөлөгдсөнөөр ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн алба хаагчдын хомсдол үүсч, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлөх эрсдэл бий болно гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д оруулсан өөрчлөлтийг хүчингүй болгон, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан уг хуулийн бусад зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулахгүй байх саналтай байна.

Жич: Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах хугацааны дагуу тооцсон цагдаагийн алба хаагчийн тэтгэврийн дунджийн зөрүү тооцоог хавсаргав.



ТЭТГЭВРИЙН ДУНДЖИЙН ЗӨРҮҮ ТООЦОО

№	Дунда ж тооцох сарын тоо	Алба хаагчийн дундаж цалин /төг/	Тэтгэвэр тогтоох хувь	Тэтгэвэр тогтоох он	Тэтгэврийн дүн /сард авах/		Зөрүү /төг/
					Хуучин хуулиар /төг/	Шинэ хуулиар /төг/	
<b>Ахлагч</b>							
1	60 сар	933,109	80%	2018 он	746,487	746,487	0
2	72 сар	944,781	80%	2019 он	786,529	755,825	-30,704
3	84 сар	953,117	80%	2020 он	796,006	762,494	-33,512
<b>Офицер</b>							
1	60 сар	1,310,206	80%	2018 он	1,048,165	1,048,165	0
2	72 сар	1,340,867	80%	2019 он	1,121,481	1,072,694	-48,787
3	84 сар	1,362,768	80%	2020 он	1,160,296	1,090,215	-70,081
<b>Ахлах офицер</b>							
1	60 сар	1,714,932	80%	2018 он	1,371,946	1,371,946	0
2	72 сар	1,753,346	80%	2019 он	1,415,511	1,402,677	-12,834
3	84 сар	1,780,785	80%	2020 он	1,460,459	1,424,628	-35,831

Ахлагч алба хаагчийн хувьд Монгол Улсын Их Хурлаас “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу 72 сараар тооцоход сард авах дундаж тэтгэврийн хэмжээ 30704 төгрөг, 84 сараар тооцоход 33512 төгрөг, офицер албан хаагчийн хувьд 72 сараар тооцоход сард авах дундаж тэтгэврийн хэмжээ 48787 төгрөг, 84 сараар тооцоход 70081 төгрөг, ахлах офицер албан хаагчийн хувьд 72 сараар тооцоход сард авах дундаж тэтгэврийн хэмжээ 12834 төгрөг, 84 сараар тооцоход 35831 төгрөгөөр тус тус буурахаар байна.

Жич: 2017-2018 онуудын цалинг Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолоор тооцлов.

— ооо —



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.06.15 № 4-3/3844

танай 2018.06.06-ны № 1/1766 -т


Санал өгөх тухай

Таны ирүүлсэн хүсэлтийн дагуу Улсын их хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Энхбаяр нараас тавьсан асуулгын 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 1-1/1904 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд хууль зүйн салбарт 2018 онд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох 685 алба хаагчид 25.8 тэрбум төгрөг шаардлагатай байгаа талаар саналаа ирүүлсэн.

2.Зэвсэгт хүчинээс 2018 онд хэчнээн алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан талаар Батлан хамгаалах яамнаас мэдээлэл ирүүлээгүй байна.

Зэвсэгт хүчин болон хууль зүйн салбарт шаардагдаж буй тэтгэвэрт гаражад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2019 оны төсвийн төсөлд тусган шийдвэрлэнэ.



Ч.ХҮРЭЛБААТАР